



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.22 № 06/22 - УАГ-САН/2013/18 - СИА-ТТЭ

**ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ХАРЪЯА ХАНГАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХЭЛТЭСНИЙ ДАРГА  
Р.ОРГИЛСАЙХАН ТАНАА**

**ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ**

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Тагнуулын ерөнхий газрын 2012 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Хангалт үйлчилгээний хэлтэс 2012 оны 12 дугаар сард Автобааз, 08 дугаар алба, Нийслэлийн тагнуулын газар, Үндэсний тагнуулын академи, 5 дугаар хэлтэст нийт 41,0 сая төгрөгийг бэлэн мөнгөний карт ашиглан бэлэн мөнгөөр санхүүжилтийг хийсэн нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 5.5-д " төлбөрийн картан дансыг өөрийн орлогыг төвлөрүүлэх, дамжсан гүйлгээ хийх зэрэг төрийн сангийн санхүүжилт авахаас бусад зориулалтаар ашиглахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих" гэж заасныг үндэслэн цаашид бусад ТЕГ-ын харъяа байгууллагуудын санхүүжилтийг төлбөрийн карт ашиглан бэлэн мөнгөөр дамжуулан санхүүжүүлэхгүй байх талаар арга хэмжээ авч зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2013 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус Хангалт үйлчилгээний хэлтсийн Санхүүгийн тасгийн дарга Б.Даваахүүд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:**


**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР**

**ЗӨВШӨӨРСӨН:**

**ХҮХ-ЫН САНХҮҮГИЙН ТАСГИЙН ДАРГА**

**Л.ОДГЭРЭЛ**

**Б.ДАВААХҮҮ**



070093